ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 25 өдөр Дугаар 1 Улаанбаатар хот

Премиум Нэксус ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("**Хурал**")-ыг 2024 оны 04-р сарын 25-ны өдрийн 11:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 2 давхарт биечлэн болон цахимаар хуралдуулав.

Хурлын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал А.Ганхуяг, Тооллогын комиссоор Голомт Капитал ҮЦК-ийн Харилцагчийн үйлчилгээний ахлах Б.Эрдэнэцэцэг (дарга), Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер Н.Халиунгоо, Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч А.Намуун нар, Хурал зохион байгуулах комиссоор Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг, Мерчандайзинг, ханган нийлүүлэлтийн газрын захирал С.Дашдорж, Конвиниенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал Д.Бүдханд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нар тус тус ажиллав.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 992,161,819 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 1,114,252,034 ширхэг энгийн хувьцааны 89.04 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлж Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 89.04 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, үг хэлэв. Компани нь 2023 онд 89 шинэ дэлгүүр, нийт 374 дэлгүүр (31% өсөлт), давтагдсан тоогоор 45 сая хэрэглэгч (34% өсөлт)-ид үйлчилж, 390 тэрбум төгрөгийн борлуулалт (50% өсөлт) хийсэн бөгөөд Премиум Нэксус ХК болж CU төвтэй хамтын ажиллагаа хөрөнгө оруулалтын платформ бизнесийн загварт шилжих эхлэлийг тавьсан. Мөн үр ашигтай логистикийн системийг хөгжүүлэн өдөрт 400,000 бараа бүтээгдэхүүнийг дэлгүүрүүдэд түгээж, Улаанбаатар хотын автомашины ачааллыг өдөрт 829 машинаар бууруулсан байна. Иймхүү Компани нь Дэлхийн стандартаар хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хялбаршуулах зорилгын дор хөрөнгө оруулагчдадаа урт хугацааны тогтвортой өсөлтийг авч ирэхээр ажиллаж байгаа тухай танилцуулаад ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондог үг хэлэхийг урив.

ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондо хувьцаа эзэмшигчдэд хандан үг хэлэв. Премиум Нэксус ХК бизнесээ хөгжүүлээд зогсохгүй нийгэмд тустай нийгмийн дэд бүтцийг бий болгохоор хичээн өнгөрсөн жил бид Улаанбаатар хот дахь дэд бүтцээ сайжруулан, чанартай, шинэ хүнс танд ойрхон CU-д үргэлж бэлэн байх боломжийг хангаж ажиллалаа. 2023 оны онцлох үйл явдлуудаас дурдвал бэлтгэсэн хүнс нийлүүлэгч 6 түнш HACCP сертификат авсан, бизнесийн орчин дах эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зорилгоор Зээлийн батлан даалтын сан болон Капитрон банктай хамтран Франчайз дэлгүүрийн эрх авч буй эмэгтэйчүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт олгож эхэлсэн, дэлгүүрийн ажилчдын цалинг долоо хоног бүр олгож эхэлсэн зэрэг олон зүйлс байна. Бид өөрсдийн санаачилгаар ТУЗ-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог байгуулан, байгаль орчин болон нийгэмд эерэг нөлөө бүхий олон төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бид үйл ажиллагаа явуулж буй бүх газартаа амьдрах таатай орчныг дээшлүүлэн, үйлчилгээнийхээ үр шимийг хүн бүхэнд хүргэхийг зорьдог. Мөн бид хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг тэгш хамгаалахын төлөө шамдан ажиллаж байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс үл хамааран, бүх хувьцаа эзэмшигчийн саналыг бид анхааралтай сонсон ажилладаг. Цаашид ч бид Премиум Нэксус ХК-ийн

бүх оролцогч талуудад илүү сайхан ирээдүйг бүтээхийн төлөө хичээн ажиллах болно. Үүнд та бүхний дэмжлэг хамгаас үнэтэй, хамтдаа бид агуу зүйлсийг бүтээж чадна. Амжилт дүүрэн ирээдүйн төлөө хамтдаа улам хичээцгээе хэмээв.

Хурлын дарга Хурлын дэг болон Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Хурлаар танилцуулах асуудалд:

(i) Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
(ii) Компанийн 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.

Хурлаар хэлэлцэх асуудалд:

(i) Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах.

Хурлын дарга Хуралд санал өгөх заавар бичлэг болон Компанийн үйл ажиллагааны тухай видеог дэлгэцээр гаргав.

1. КОМПАНИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн Гүйцэтгэх захирлын орлогч Г.Чинзориг Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав. Премиум Нэксус ХК нь 2023 онд ТОП 100 аж ахуйн нэгжийн жижиглэн худалдааны салбарт 1-р байр, ТОП 100 аж ахуйн нэгжийн 11-р байр, МХБ топ 20 индексэд багтсан бөгөөд нэг өдөрт 150,000 гаруй хэрэглэгчдэд үйлчилдэг 375 дэлгүүртэй Монголын хамгийн олон салбартай сүлжээ дэлгүүр болсон байна. Компани нь 2023 онд зах зээлд манлайлах, дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, ялгарал бий болгох, үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх стратегийн зорилтуудыг тавьж ажилласан бөгөөд 390 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалт хийж үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувьд нийт 4308 ажиллагсадтай, 18.9 тэрбум төгрөгийн татвар төлж, давхардсан тоогоор 45.2 сая хэрэглэгчдэд үйлчилж, 432.2 тэрбум төгрөгийн нийт сүлжээний борлуулалт хийсэн байна. Тайлант хугацаанд Компани нь зах зээлийн тэлэлт хийж орон нутагт Улаанбаатар хотоос 380 км зайд 20 дэлгүүр шинээр нээж CU брэндийн стандарт үйлчилгээг орон нутгийн хэрэглэгчдэд үзүүлж байна. Мөн нийт 47 дэлгүүрийн франчайз эрх өгч, франчайз бизнес эрхлэгчдэдээ дэлгүүрийн үйл ажиллагааг амжилттай удирдахад шаардагдах мэдлэг болон ур чадварыг ойлгох сургалтуудад хамруулсан бөгөөд 2023 оны 5-р сард Зээлийн батлан даалтын сан, Капитрон банктай хамтран НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн 5-р зорилго буюу Жендерийн эрх тэгш байдлыг хангах, Эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоог нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан уян хатан шалгууртай, батлан даалттай бизнесийн зээлийг бага хүүтэйгээр авах боломжтой хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

CU дэлгүүрийн хэрэглэгчийн худалдан авч буй бүтээгдэхүүний 51 хувь нь үндэсний үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн байгаа нь CU брэнд дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулалт үйлчилгээний цар хүрээгээ тэлж, бизнесээ өргөжүүлэх боломжийг олгож байна. Мөн нийт бараа бүтээгдэхүүний 99 хувийг нарийн ангилж, нэгдсэн түгээлтийн төвөөр дамжуулан түгээснээр нэг салбар дэлгүүрийг өдөрт 4 удаагийн хүргэлтээр бараа бүтээгдэхүүнээр бүрэн хангах боломжтой болсон. 2023 онд CU апп технологийн цогц шийдэл болон шинэчлэл хийж, CU Кредит картын үйлчилгээ, CU апп дотроос төлбөр төлөх, цаасгүй И-баримт уншуулах боломжтой болсон бөгөөд CU апп-ын сар бүрийн идэвхтэй 154 мянган хэрэглэгчид байна. Компани нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой эерэг хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ

итгэл найдварыг өндөрт хадгалж, салбартаа манлайлж ажиллахыг зорьж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 15 зорилгод хувь нэмрээ оруулж байгаа тухай танилцуулав.

Компанийн 2023 оны санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитораар ажилласан Кэй Пи Эм Жи Аудит ХХК аудиторын дүгнэлтийг, Конвиниенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал Компанийн 2023 он болон 2024 оны 1-р улирлын санхүүгийн үзүүлэлт, санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн санхүүгийн тайланг, Гүйцэтгэх захирлын орлогч 2024 оны 1-р улирлын онцлох гол үйл явдлын талаар танилцуулав.

Компанийн орлого үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн хувьд 2023 онд 432.3 тэрбум төгрөгийн системийн борлуулалт хийсэн ба борлуулалтын цэвэр орлого 390.5 тэрбум төгрөг, борлуулалтын өртөг 393.4 тэрбум төгрөг, нийт ашиг (алдагдал) -2.9 тэрбум төгрөг, нийт цэвэр ашиг (алдагдал) -32.7 тэрбум төгрөг байна. 2022, 2023 оны санхүүжилтийн мөнгөн гүйлгээнээс санхүүгийн түрээсийн төлбөрийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ рүү шилжүүлж тохируулсан. 2023 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ -6.5 тэрбум төгрөг, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн 38.7 тэрбум төгрөг байсан байна.

Компанийн 281 харьцуулсан дэлгүүрийн 2024 оны 1-р улирлын өдрийн дундаж борлуулалт 28 хувь, өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо 14 хувь, сагсны үнэ 12 хувиар өссөн бөгөөд нийт 375 дэлгүүрийн хувьд өдрийн дундаж борлуулалт 19 хувь, өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоо 6 хувь, сагсны үнэ 12 хувиар тус тус өссөн байна. М1 мөнгөний нийлүүлэлт сүүлийн 12 сард 44 хувь, харин М2 мөнгө 21 хувиар тус тус өссөн нь эдийн засгийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, эрэлтийг суурь жилтэй харьцуулахад нэмэгдүүлсэн үр дүн гарахад нөлөөлсөн. Мөн 2024 оны 2-р сараар жилийн инфляц Улаанбаатар хотод 7.2 хувь байхад хэрэглэгчдийн сагсны үнэ 12 хувиар өссөн нь худалдан авагчдын сагсны хэмжээ бодит өсөлт үзүүлсэн.

2024 оны 1-р улиралд нэгтгэсэн орлого, үр дүнгийн тайлангаас харахад Компанийн борлуулалтын цэвэр орлого 110.9 тэрбум төгрөг, борлуулалтын өртөг 103.3 тэрбум төгрөг, нийт ашиг 7.6 тэрбум төгрөг, тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) -0.8 тэрбум төгрөгт хүрч 13.3 фунтээр өссөн байна. Үүнээс үзэхэд Компани нь 2024 оны 2-р улиралд орлого, үр дүн эерэг гаргах боломжтой байна.

Асуулт 1. Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Цаашид Компани орон нутгийн тэлэлт хийх үү, логистикийн асуудлыг хэрхэн шийдэх, хүнс түргэн муудаг бүтээгдэхүүн тул аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ, орон нутгийн бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтарч ажиллахаар төлөвлөсөн үү.

Хариулт 1. Компани нь цаашид орон нутагт тэлэлт хийнэ, орон нутагт түгээлт хийхэд цаг ордог. 1. Компанийн хувьд хамгийн түрүүнд савтай хоол дээр химийн нэмэлт хийхгүйгээр хоолны хугацааг уртасгадаг технологид хөрөнгө оруулалт хийж байна. 2. Орон нутгийн бизнесийг дэмжихтэй холбоотой бүсчилсэн судалгаа хийж байгаа ба зарим түргэн муудах хүнсийг тухайн орон нутгийн үйлдвэрлэгч нараас худалдан авах боломжтой гэж үзэж байна. Өглөө шинэ хүнс бэлэн байлгахын тулд орон нутгийн түгээлтийг шөнийн цагаар хийх шаардлага гарч байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал талдаа эрсдэлтэй гэж үзэж байгаа тул өөрчлөх шийдлүүдийг хайж байна.

Асуулт 2. Хувьцаа эзэмшигч Р.Энхтуяа: Хувьцааны үнийг хэрхэн тогтворжуулах, ногдол ашиг хэзээ тараах, нэгтгэсэн компаниудын санхүүгийн тайланд орсон эсэх, Компанийн өртөг яагаад орлогоос өндөр байсан, тэлэлт хийх тусам алдагдалтай ажиллаж байна, жил бүр алдагдал нэмэгдэж байна.

Хариулт 2. IPO хийх үед алдагдалтай байсан, ашигтай ажиллахын төлөө, хөрөнгө оруулалтын өгөөжийг гаргаж өгөхөөр 4,300 хүн бид бүгд мэрийн ажиллаж байна. Бид 2023 онд 32 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан ч 2024 оны 1-р улиралд 800 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж өмнөх алдагдлаа нөхөөд явж байна, энэ нь Компани ашигтай ажиллах бүрэн боломж байгааг

харуулж байна. Цаашид тэлэх тусам ашиггүй ажиллана гэсэн онол байхгүй, Компанийн хувьд дэлгүүрийн тоо нэмэгдэхийн хэрээр сагсны хэмжээ 12 хувиар өссөн. Дэлгүүрийн тоо нэмэгдэх тусам Компани тогтвортой бизнес хийх боломж нэмэгдэнэ. Борлуулалтын өртөгт дэлгүүрийн элэгдэл, дэлгүүр дээрх хүмүүсийн цалин, ашиглалт, ариутгал цэвэрлэгээ, хангамж гэх мэт бүх зардал ордог, хүмүүс үүнийг хуучин тайлагналын стандарттай андуураад байдаг. IPO хийж хөрөнгө оруулалт татсан компани босгосон мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийж байж өгөөж бий болгодог. Манай хувьцаа эзэмшигчид хөгжлийн төлөө хөрөнгө оруулалт хийсэн, бид хөгжлийн төлөө ажиллаж байна, мөнгөний хуримтлал бий болж байна. Орон нутаг хөгжих ёстой, бид дэмжлэг үзүүлж урт хугацааны боломжийг бий болгохын тулд хөрөнгө оруулалт хийж байна. Энэ нь ирээдүйд манай Компанийн үнэ цэн өсөх, хувьцааны үнэ өсөх суурь болно гэж найдаж байна. Компанийн санхүүгийн тайланд аудитор "full scope" буюу иж бүрэн шалгалт хийн бүх зүйлийг шалгасан. Орлого хүлээн зөвшөөрөлт нь аудитын хувьд хамгийн чухал асуудал тул энэ талаас онцолж ярьсан. Санхүүгийн тайлангийн хувьд 2023 оны Компани дангаараа, 2024 оны нэгтгэсэн тайлан танилцуулсан.

Асуулт 3. Хувьцаа эзэмшигч Самбууням: Компани нийт алдагдал 32 тэрбум төгрөг болон хуримтлагдсан алдагдал 110 тэрбум төгрөг нөхсөний дараа ногдол ашиг тараах уу.

Хариулт 3. Компанийн ногдол ашгийн бодлогын дагуу ногдол ашиг хуваарилах хоёр нөхцөл бүрдсэний дараа ногдол ашиг зарлах боломжтой болно. Компани ногдол ашиг тараах замаар эсвэл хувьцааны үнэ өсөх замаар өгөөжөө өгдөг. Ихэнхдээ цаашид өсөх боломжтой бизнес хөрөнгө оруулалт хийдэг, цаашид бид өсөлттэй байх боломжтой гэж үзэн хөрөнгө оруулалт хийж байна. Дэд бүтцийн төсөл бол их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Бид алдагдалтай ажилласан ч, хөрөнгө оруулагч нар маань анзаарч харах юм бол Компанийн хувьцааны үнэ өсөж гэж найдаж байна.

2. КОМПАНИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 болон Компанийн Дүрмийн 9.4.9-р заалтыг тус тус үндэслэн Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулав.

Компани нь 2023 онд 89 салбар дэлгүүрийг нээж, мэдээлэл технологийн системээ сайжруулж, түгээлтийн дэд бүтцээ олон улсын стандартын шаардлагад нийцүүлж нийт бүтээгдэхүүнийхээ 99 хувийг өөрийн түгээлтийн сүлжээгээр дамжуулан хэрэглэгчдэд очих эцсийн үйлчилгээний чанараа дэлхийн жишигт хүргэх нөхцөлийг бүрдүүлжээ. Ингэснээр компани стратегийн зорилтуудаа амжилттай биелүүлэхэд шаардлагатай суурь дэд бүтцээ амжилттай байгуулж, үйл ажиллагааны процессыг тогтоож чадсан байна.

Мөн франчайз хөтөлбөрийг илүү олон жижиг дунд бизнес эрхлэгчид хүргэх, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Зээлийн батлан даалтын сан, Капитрон банктай хамтран байгууллагуудтай хамтарсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Тайлант оны эцэст өдөрт 150 мянган хүн үйлчлүүлдэг 374 салбар дэлгүүртэй болжээ. Компани нь 2023 онд 4,308 ажилтантайгаар, нийт 102 мянган хүн цаг сургалтыг хийж, 49.2 тэрбум төгрөгийн цалин урамшууллыг олгож, ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэхэд анхааран ажилласан байна. Мөн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг хийлгэсэн бөгөөд НҮБ-ийн тогтвортой хөгжлийн баримт бичгийн хүрээнд гарсан ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, энх тайван, шударга ёс зэрэг 17 зорилгоос 15 зорилгыг биелүүлж нийгэмд хувь нэмрээ оруулж ажилласан байна. Иймд Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ дүгнэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. **Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах**: зөвшөөрсөн 990,710,669 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн хувьцаа 0 ширхэг буюу 0 хувь байна.

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Премиум Нэксус ХК ("**Компани**")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 04-р сарын 25-ны өдрийн ээлжит хурал ("**Хурал**")-ын шийдвэр болон Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

Ийнхүү хэлэлцэх асуудал дууссан тул Хурлын дарга Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид болон асуулт асууж, яриа өрнүүлж бусад хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл авах боломжийг олгосон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлээд Хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА А.ГАНХУЯГ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: Т.ГАНТУЛГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА